



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/653

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн цахим түүх аудио номыг MP3 файлаар диск болгон чанарын өндөр түвшинд хэвлэн 500 ширхэг хавтастай ном болгох ажлыг 20,000,000 (хорин сая) төгрөгөөр “Эрдэнэсүврэй” ХХК-тай гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

2.Гэрээнд заасан ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг “Эрдэнэсүврэй” ХХК-ын захирал (Д.Од-Эрдэнэ)-д даалгасугай.

3.Санхүүжилтийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ

